БАТЛАВ: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА Ж.ОД

СЭЛЭНГЭ АЙМАГ, ЕРӨӨ СУМ, БУГАНТ ТОСГОН "10 ОРТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ" –ИЙН БАРИЛГЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Огноо: 2023-05-18 Дугаар 03 Ерөө сум

1. Зураг төсөл зохиох үндэслэл	- Төсвийн тухай хууль - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум Аймгийн Засаг даргын захирамж-н 2010/04/20-нд, 04301-129/2010 тоот захирамж
2. Барилга байгууламжийн байршил	Сэлэнгэ аймаг Ерөө сум Бугант тосгон
3. Зориулалт, хүчин чадал	10 ортой Эрүүл мэндийн төвийн барилга:
4. Одоогийн байдал	Бугант тосгоны эрүүл мэндийн төвийн хуучин барилгад
5. Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6. Төслийн захиалагч	Эрүүл мэндийн газар, Бугант тосгоны эрүүл мэндийн төв
7. Төсөл боловсруулах байгууллага.	Барилга хот байгуулалтын яамны сайдын тушаалаар батлагдсан "Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий компани.
8. Төсөл боловсруулах үе шат	Судалгаа - Байр зүйн зураглал - Инженер геологийн судалгааны дүгнэлт Техникийн төсөл - Загвар зураг /эскиз/ Ажлын зураг төсөл - Иж бүрэн ажлын зураг төсөл боловсруулах - Төсөв Захиалагч байгууллагын саналыг тусган эх загвар зургийг зөвшилцөн ажлын зураг төслийг хийж гүйцэтгэнэ.
9. архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	Ерөнхий төлөвлөгөө - Гадна зам талбайн хөдөлгөөнийг гол гудамж, замын хөдөлгөөнтэй уялдуулан ерөнхий төлөвлөгөөний замын үндсэн сүлжээтэй уялдуулан төлөвлөх: - Авто зогсоолыг норм, дүрмийн дагуу төлөвлөж, орц, гарцыг явган замтай огтлолцохгүй байхаар зураг төсөлд тусгах:

	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих зам, талбайг норм стандартын дагуу төлөвлөх - Гадна орон зайн төлөвлөлтөд архитектурын элементийг үндсэн цогцолбор барилгатай уялдуулан норм, дүрэмд нийцсэн байхаар төлөвлөх - Гадна талбайн ногоон байгууламжийг стандартад нийцүүлэн төлөвлөх Барилга, байгууламж - "10 ортой эрүүл мэндийн төв"–ийн барилга байгууламж нь архитектур, орон зайн оновчтой орчин үеийн дэвшилтэт технологийг тусгасан "СМАРТ", байгаль орчинд ээлтэй "ЭКО" шийдэлтэй байх - Барилгын орон зайн функционал шийдлийг оновчтой тодорхойлох - Амбулаторийн үзлэгийн өрөө, Хэвтэн эмчлүүлэгчийн өрөө, Дархлаажуулалтын өрөө, Төрөх өрөө, Төрөхийн өмнөх өрөө, Төрөхийн дараах өрөө, Гал тогоо, Ажилчдын өрөө, Сургалтын өрөө, Ажилчдын ариун цэврийн өрөө, Үйлчлүүлэгчдийн ариун цэврийн өрөө, Агуулах, Архив болон бусад шаардлагатай өрөө тасалгаануудыг норм, стандартын дагуу төлөвлөх. Ногоон байгууламж - Тохижилтыг орчны архитектур орон зайн төлөвлөлттэй уялдуулан хогийн сав /ангилан ялгах/, сандал, саравч гэх мэт архитектурын жижиг хэлбэрүүдийг төлөвлөх, Архитектур орон зайн төлөвлөлтөд нийцсэн ландшафтын шийдэл бүхий тохижилтын элементүүдийг явган зорчигчийн хөдөлгөөнд саад учрахгүй байхаар төлөвлөх - Гадна явган зам талбай, авто зогсоол, ногоон байгууламж зэргийн өнгө, зай хэмжээ, материалын чанар, хэлбэр, нэр төрлийг нарийвчлан тусгах - Гадаргуугийн ус болон хэрэглээний усыг дахин ашиглаж орчны ногоон байгууламжид хэрэглэх
10. Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	- Төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох - Төвлөрсөн цахилгаан хангамжийн системд холбох - Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугамд холбох - Мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээнд холбох

	- Галын дохиоллыг аймгийн Онцгой байдалд шууд мэдээлэл очдог байхаар төлөвлөх
11. Төсөлд ашиглах материал	Монгол Улсын хууль - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Газрын тухай хууль Норм, нормативууд - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад ашиглагдах норм ба дүрэм - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм - Олон нийтийн барилгын норм дүрэм - Захиргааны зориулалттай олон нийтийн барилга - Эмнэлгийн зориулалттай барилгын төлөвлөх - Өндөр барилгын төлөвлөлт - Авто зогсоол - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм - Барилгын төсөв зохиох дүрэм - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн норм ба дүрэм, стандарт, MNS
12. Төслийн иж бүрдэл	Иж бүрэн ажлын зураг төсөл - Инженер геологийн дүгнэлт - Дэвсгэр зураг - Нүүр хуудас / батлагдах / - ЕТ /ерөнхий төлөвлөгөө, өндөржилт, зай хэмжээ, картограмм/ - Ландшафтын зураг төсөл - БА /барилга архитектур/ - ТХ /технологи/ - ББ /барилга бүтээц/ - ХС / халаалт, салхивч, хөргөлтийн систем/ - ЦБУ /усан хангамж, ариутгах татуурга/ - ЦА /цахилгаан хангамж/ - ХД /холбоо дохиолол/ - ГД /гадна дулаан хангамж/ - ГДА /гадна дохиолол ба автоматик/ - УАТГ /гадна ус хангамж ариутгах татуурга - ГЦ /гадна цахилгаан/ - ГХ /гадна холбоо/ - Барилгын төсөв - Магадлалын ерөнхий дүгнэлт Зураг төслийг хүлээлгэн өгөх

	- Барилгын зураг төсөлд Магадлалын ерөнхий дүгнэлт хийлгүүлсэн байх - Инженер геологийн дүгнэлт /Магадлалын ерөнхий дүгнэлттэй/ - Боловсруулж дуусан иж бүрэн ажлын зураг төслийг 3 хувь хүлээлгэн өгөх - Зураг төслийг цахим хэлбэрээр хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага 1. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх 2. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн UTM солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх
13. Онцгой нөхцөл	Газар хөдлөлтийн 7 балл - Шинээр төлөвлөх шугам хоолой нь газрын дээрх болон доорх шугам сүлжээ, барилга байгууламжтай огтлолцохоор бол мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх. - Шугам сүлжээний зураг төсөв боловсруулах, угсралтын ажлыг гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд хэмнэлттэй, орчин үеийн дэвшилтэт техник технологи, материал ашиглахаар тусгаж өгөх. - Ажлын зураг төслийг боловсруулахдаа одоо мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж холбогдох норм ба дүрмийг баримталж гүйцэтгэнэ. - Хөрсний усны төвшингийн, их суулт , овойлт үүсгэх, мөнх цэвдэг хөрс зэрэг инженер геологийн онцгой нөхцөлтэй хөрсөнд төлөвлөхдөө эвдрэл гэмтэл, хэв гажилтаас хамгаалах арга хэмжээнүүдийг холбогдох норм дүрэм зааврын дагуу авахад орчин үеийн дэвшилтэт технологийг тусгах. -Газар дээр хэмжилт хийх.
17. Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ	Төсвийг БНбД 81-95-12 дагуу ESTIMATOR -pro программ болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад програмаар тооцно.

Хянасан:
Сэлэнгэ аймгийн ерөнхий архитектор Б.ХАНГАЛ

Зөвшөөрсөн:
Аймгийн Эрүүл мэндийн газрын удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга Э.САНАА-АМАР

Боловсруулсан:

Аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн С.ӨЛЗИЙБҮРЭН